НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ц.Жигжиджавын гудамж-7/1,
Хангарди ордон
Утас: 31-80-03, Факс: (976-11) 32-06-69
http://www.baigal.ub.gov.mn

2016 · 12 · 14 № 1/1422
танай 2016 · 11 · 07 -ны № 256/2016 -т

"ТҮМЭН ШУВУУТ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ж.БОЛД ТАНАА

Нийслэлийн Хан-Уул дүүргийн 13-р хорооны нутаг дэвсгэрт хэрэгжих "Сангас боловсруулах цех " төслийн баримт бичигт "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, "Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам"-ын 3 дахь хэсгийг үндэслэн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлээ.

Уг үнэлгээнд тусгагдсан нөхцөл болзлуудыг хэрэгжүүлж ажиллана уу.

Хавсралт 3 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ШИНЖЭЭЧ Э.БАТТУЛГА

1116129779
УОА0039 9077049

1150502346

## ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУУДАС

**2016 оны 12-р сарын 14-нд** **Улаанбаатар хот**

**Төслийн дугаар** **2016/146**

**Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг:** “Түмэн шувуут” ХХК Хан-Уул дүүргийн 13-р хороо, Туул тосгон, Шувуун фабрик гудамж

**Төслийн нэр:** “Сангас боловсруулах цех /үйлдвэр/”

**Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил:** Улаанбаатар хотын, Хан-Уул дүүрэг, 13-р хороо, Шувуун фабрик гудамж

**Холбоо барих утас: 70005225,88112490**.

| | Ерөнхий үнэлгээний гол шалгуурууд | Нийцсэн | Нийцээгүй | Нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай | Үндэслэл тайлбар |
|---|---|---|---|---|---|
| Төрийн бодлого, шийдвэрийн нийцэл | Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагад | Тийм | | Шаардлагагүй | |
| Төслийн байршил, түүнтэй холбогдох шалгуурууд | Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх (урсац бүрэлдэх эх, ойн болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, хилийн хамгаалалтын бүс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар г.м) | Тийм | | Шаардлагагүй | |
| | Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг, мэдрэмтгий эсэх | Тийм | | Шаардлагагүй | |
| | Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсгэх эсэх | | | | Хуримтлагдах нөлөөлөл үүсгэхгүй |
| Төслийн байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ | **Агаарын чанар** | | | | |
| | Бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгаруулах, эсэх | | | | Үүсгэхгүй |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх, эсэх | | | | Үүсгэхгүй |
| | **Усан орчин** | | | | |
| | Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх, эсэх | | | | Үүсэхгүй |
| | Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх | | | | Нөлөөлнө |
| | Гадаргын болон газрын доорх усанд бохирдол үүсэх, эсэх | | | | |
| | **Хөрсөн бүрхэвч** | | | | |
| | Хөрсөн бүрхэвч эвдрэх, эсэх | | | | Нөлөөлөхгүй |
| | Хөрс бохирдуулах эсэх | | | | |
| | Хөрс доройтох, цөлжих эсэх | | | | |
| | **Ургамлан нөмрөг** | | | | |
| | Ургамлан нөмрөг, ой мод өртөх эсэх | | | | Ургамлан нөмрөг өртөхгүй. |
| | Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлс өртөх, эсэх | | | | Суурьшлын бүсэд байрлалтай ховор, нэн ховор ургамалд нөлөөлөхгүй |
| | **Амьтны аймаг** | | | | |
| | Зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтуулах, эсэх | | | | Суурьшлын бүсэд байрлалтай амьтдын амьдрах орчинг доройтуулахгүй |
| | Ховор, нэн ховор амьтан өртөх, эсэх | | | | |
| Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ | **Нутгийн оршин суугчид** | | | | |
| | Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөх, эсэх | Тийм | | | Суурьшлын бүсэд байрлалтай нөлөөлөлд өртөхгүй |
| | Нутгийн оршин суугчдын нийгмийн байдалд сөрөг нөлөөлтэй, эсэх | | | | |
| | Нөлөөлөлд өртөж болзошгүй төв, суурин газар байгаа, эсэх | | | | Суурьшлын бүсэд байрлалтай нөлөөлөлд |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх, эсэх | | | | өртөхгүй |
| | **Түүх, соёлын биет өв** | | | | |
| | Сөрөг нөлөөлөлд өртөх түүх, соёлын үнэт зүйлс бий эсэх | | | | Суурьшлын бүсэд байрлалтай нөлөөлөлд өртөхгүй |
| | **Хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл** | | | | |
| | Нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эсэх | | | | Суурьшлын бүсэд байрлалтай нөлөөлөлд өртөхгүй |
| | Төслийн бүх үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэл үүсэх эсэх | | | | |

**Нэгдсэн дүгнэлт:**

**Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 13-р хороонд байрлах “Сангас боловсруулах цех /үйлдвэр/ ” төсөлд хийсэн ерөнхий үнэлгээ хийснээр уг төслийг нөхцөл болзолтойгоор хэрэгжүүлэх боломжтой гэж үзлээ.**

**Онцгойлон анхаарах зүйлс:**

1. Төслийн үйл ажиллагаа болон ахуйн хэрэглээнээс гарах хатуу, шингэн /аюултай/ хог хаягдлын хэмжээ, эх үүсвэрийг тодорхойлж, байгаль орчин, хүний эрүүл мэндэд халгүй аргаар цуглуулах, хуримтлуулах, ангилан ялгах, зайлуулах, боловсруулах зөвлөмж, технологийн дарааллыг тодорхойлж, графикт хугацаанд нэгдсэн хог хаягдлын цэгт зайлуулж байхаар харьяа дүүргийн ТҮК-тэй гэрээ байгуулан ажиллах;
2. Үйл ажиллагааны талаар мэргэжлийн байгууллагаас өгсөн заавар зөвлөмжийг бүрэн дагаж мөрдөх, “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин эрүүл ахуйн шаардлага” MNS 4990:2015, стандартыг чанд баримтлан ажиллах;
3. Орчны талбайг засаж тохижуулах зам талбайг тэгшлэх, эзэмшил газрын 20 хүртэлх хувьд мод, бут, сөөг, зүлэг тарьж ургуулах түүнд шаардагдах хөрөнгө зардлыг төсөвтөө суулгах;
4. Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад байгалийн гамшиг болон хүний буруугаас үүдэн гарч болзошгүй ослын үнэлгээ хийж, тэдгээрээс сэргийлэх арилгах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлыг төлөвлөх мөн явцад гарах үүсэх тоос, дуу чимээний бохирдолыг багасгаж иргэдийн эрүүл амьдрах орчинд нөлөөлөхгүй байхаар төлөвлөж төлөвлөгөөнд тусгах
6. Хөрс, ус, агаараас дээж авах цэгийг холбогдох стандартын дагуу тогтоож, шинжилгээнд дээж авах зөвлөмжийг тусгах, үнэлгээний шатанд хөрсний тодорхой гүнээс дээж авч шинжилгээнд хамруулан дүнг тайланд хавсаргах;
7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайланг /Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр/ боловсруулж жил бүрийн 1 улиралд багтаан тус газраар батлуулах.

| | |
|---|---|
| Ерөнхий үнэлгээ хийсэн<br>Овог, нэр: **Б.Хүдэр**<br>Алба тушаал**: Нийслэлийн Байгаль орчны газрын мэргэжилтэн**<br><br>Гарын үсэг:<br><br>Огноо ...2016.12.14... | Ерөнхий үнэлгээний үр дүнг зөвшөөрсөн:<br>Овог, нэр : **Ж.БОЛД**<br><br>Алба тушаал: **Захирал**<br><br>Гарын үсэг:<br><br>Огноо: ...2016.12.14... |